



**СҮХБААТАР ДҮҮРЭГ ДЭХ ЦАГДААГИЙН ГАЗРЫН  
НЭГДҮГЭЭР ХЭЛТСИЙН ШААРДЛАГА**

2020.11.11

№ 20209089

Улаанбаатар хот

/30 дугаар зүйл. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хуулийн этгээдийн нийтлэг үүрэг/

30.2. Гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг арилах, гэмт хэрэг, зөрчил үйлзэгдэхээс урьдчилан сэргийлэх талаар энэ хуулийн 13.1.4-т зааснаас бусад этгээдийн мэдээдэл, зөвлөмж, шаардлагыг хүлээн авсан хуулийн этгээд түүний дагуу тодорхой арга хэмжээг авч, хариуг хугацаанд нь өгөх үүрэгтэй.

Цагдаагийн албаны тухай хууль. /64 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах/

64.4. Цагдаагийн байгууллага гэмт хэрэг, зөрчил үйлзэгдсэн, үйлзэгдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоох, тэдээрийг арилуулах талаар ирээн, хуулийн этгээдэд хуулиар хүлээсэн үүргийн нь хүрээнд шаардлагыг тавьж, биелэлтийг шалгах шаардах, холбогдох материалыг ирээн, хуулийн этгээдээс саадгүй гаргыулсан авна.

64.5. Иргэн, хуулийн этгээд цагдаагийн байгууллага, алба хаагчийн таавьсан шаардлагын дагуу тодорхой арга хэмжээ авч, тогтоосон хугацаанд хариу мэдэгдэх үүрэгтэй.

Зөрчлийн тухай хууль. /5.9 дүгээр зүйл. Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих/

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүрэгээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нээжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нээжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчлийн тухай хууль. /15.2 дугаар зүйл. Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах/

15.2.1. Төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан бол хүнийг хоёр зуун тавин нээжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нээжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэснийг анхаарна уу.

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН 6-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ЯВУУЛДАГ Цагдаагийн хамтран ажиллах талаар ХХК-НЫ ЗАХИРАЛ ТАНАА

Цагдаагийн хамтран ажиллах талаар

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай А/1241 дугаартай захирамжийн 1 дэх хэсгийн 1.1-т олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан, тэмцээн уралдаан, аялал зугаалга, сургалт, бүх төрлийн баар, тоглоомын газар, сүм хийд, мөргөлийн газрууд урлаг соёл, үзвэр үйлчилгээний газар, спортын арга хэмжээ /цанын бааз, спорт заал, билльярд, саун, бассейн, фитнес, бүжиг, иогийн клуб г.м/ болон амралт, жуулчны бааз, дэн буудлын үйл ажиллагааг түр зогсоосон байна.

Иймд та бүхэн дээрх захирамжийн хүрээнд цагдаагийн байгууллагаас өгч буй шаардлагыг хэрэгжүүлж байгууллагынхаа үйл ажиллагааг зогсоохыг үүгээр мэдэгдэж байна.

Шаардлагын хариуг 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн 201 тоотод ирүүлж хамтран ажиллана уу.

Цагдаагийн байгууллагаас өгсөн энэхүү шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, биелүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйл, 5.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлд тус тус заасны дагуу хуулийн хариуцлага тооцохыг анхаарна уу.

ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Я.ГАНБАТ